

Санхүүгийн хяналт шалгалт  
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2022 оны 06 сарын 17-ны өдрийн 1/15 тоот удирдамж аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, эрүүл мэндийн холбогдох хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2022 оны 09 дугаар сарын 19-өөс төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Эрүүл мэндийн төвийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамрууллаа.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн орон тоог Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 тоот тушаалаар эрүүл мэндийн төвийн дарга 1, эмчлэгч их эмч 2, сургалтын арга зүйч 1, эх баригч, бага эмч 1, статистикч бага эмч 1, сувилахуйн арга зүйч 1, багийн эмч 5, статистикч эмч 1, сувилагч 5, туслах сувилагч 1, вакциначуурын сувилагч 1, хөтөч сувилагч 1, нягтлан бодогч 1, нярав 1, тогооч 1, жолооч 1, асрагч 3 нийт 25 орон тоо баталсан байна.

Тус эрүүл мэндийн төвийн гарын үсгийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 09 дүгээр сарын 22-нийг дуусталх хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Л.Амарсанаа, 2021 оны 09 дүгээр сарын 22-оос 2021 оны 12 дугаар сарын 31-ныг

дуусталх хугацаанд 1 дүгээр гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Р.Эрдэнэтуул, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 18 хүртэлх хугацаанд нягтлан бодогч Б.Чанцалдулам, 2021 оны 10 дугаар сарын 18-аас 11 дүгээр сарын 08-ныг хүртэлх хугацаанд нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ, 2021 оны 11 дүгээр сарын 08-аас 2021 оны 12 дугаар сарын 31-ныг дуусталх хугацаанд Б.Нямжаргал нар төрийн санд бүртгэлийн 100040120001 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040120401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТА В. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитаас 2021 оны санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгсөн байна.

Төрийн аудитын 01/148 тоот албан шаардлагаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31 удаагийн 601426.7 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 158197.9 мянган төгрөгийн зарлага, 7 удаагийн 47747.5 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т /5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг/, 6.4.5-д/ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр/, аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг хэрэгжүүлж хариуг 2022 оны 06 дугаар сарын 10-ны хариу ирүүлэхээр даалгасанг хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна

Төрийн аудитын 02/149 тоот албан шаардлагаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг Эрүүл мэндийн төвийн дарга 2021 оны 12 дугаар сарын А/18 тоот тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилсон. Тооллого хийж дууссан тухай илтгэх хуудас байхгүй, тооцооны нэг маягтаар үндсэн хөрөнгө, бараа материалыг нийтэд нь 864624.2 мянган төгрөгөөр тооцоолжээ. 2021 оны 12 дугаар сарын 15-аас 31-ний хооронд бараа материалд 35768.4 мянган төгрөгийн орлого, 14107.1 мянган төгрөгийн зарлагын хөдөлгөөн орсон ч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т / эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1- т /хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна/ гэж заасны дагуу хариуцлаггүй хандсан, хууль, тогтоомжид заасны дагуу бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч албан шаардлагын хариуг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг даалгасанг хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Төрийн аудитын 03/150 тоот албан шаардлагаар тайлант хугацаанд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 17127.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, харилцагч 20 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т /төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/ заалтыг хэрэгжүүлж хариуг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг даалгасанг хариуг хүргүүлсэн байна.

## ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад тус сургууль 2021 онд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2022 онд 8 дугаар сарын байдлаар 109 мэдээлэл мэдээлхээс 108 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн

### ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус эмнэлгийн 2021 оны касс, харилцахын баримт, бараа материалын тайлан, эмийн тайлан, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, цалингийн цэс, цаг ашиглалтын бүртгэл, тооллогын бүртгэл, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Б.Нямжаргал, нярав Д.Батсүрэн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

**8.1.Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:** 2021 онд улсын төсвөөс 456636.7 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар 284343.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 166.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 38156.6 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 246020.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56339.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн санхүүжилтээр 24962.2 мянган төгрөг бүгд 822342.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 402899.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 52171.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2594.1 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 49555.5 мянган төгрөг, цэвэр бохир ус 100.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 4242.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 21102.1 мянган төгрөг, шуудан, холбооны зардалд 2787.7 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгалын зардалд 6417.1 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 3945.0 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 147842.1 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 16940.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 3500.0 мянган төгрөг, багаж техник, хэрэгсэлийн зардалд 10225.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2800.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 2158.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 4915.2 мянган төгрөг, даатгалын хураамж 58.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татвар 119.8 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн оношлогоо 35.0 мянган төгрөг, газрын төлбөр 40.5 мянган төгрөг, банк, санхүүгийн байгууллагын хураамж 34.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8053.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 46238.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 12764.9 мянган төгрөг, бусад хөрөнгө 1350.0 мянган төгрөг нийт 802722.9 мянган төгрөг зарцуулж 19619.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:** Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 04 сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар 21 эмч ажилчдын 1 дүгээр улирлын ажлыг дүгнэж 36.6-43 %-аар үр дүнгийн урамшуулалд 5964.5 мянган төгрөг, 07 дугаар сарын 09-ны өдрийн А/10 тоот тушаалаар 2 дугаар улирлын ажлын үр дүнг шалгуур

үзүүлэлтээр дүгнэсний дагуу 21 эмч ажилчидад 28-43%-аар 5961.5 мянган төгрөг, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/15 тоот тушаалаар 3 дугаар улирлын 21 эмч эмнэлгийн ажиллагсадад 45%-аар 6018.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/20 тоот тушаалаар 4 дүгээр улирлын урамшуулал 21 эмч, эмнэлгийн ажилтануудад 30-45%-аар 6053.0 мянган төгрөг, 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/11 тоот тушаалаар коронавируст халдварын үед ажилласан эмч, эрүүл мэндийн 24 эмч эмнэлгийн ажилтнуудад тус бүр 1000.0 мянган төгрөг нийт 24000.0 мянган төгрөг, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот тушаалаар коронавируст халдварын үед ажлласан 23 эмч эмнэлгийн ажилтануудад тус бүр 366.7 мянган төгрөг нийт 8433.3 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/27 тоот тушаалаар 2021 оны ажлаараа шилдгээр шалгарсан эмч эмнэлгийн 6 ажилчидад тус бүр цалингийн 45%-аар 1906.9 мянган төгрөг нийт 58337.2 мянган төгрөг олгосон байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/39 тоот захирамжаар 1 дүгээр улирлын урамшуулал 43%-аар 402.0 мянган төгрөг, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Б/31 тоот захирамжаар 3 дугаар улирлын урамшуул 45%-аар 371.5 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Б/32 тоот захирамжаар 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 45%-аар 371.5 мянган төгрөг, 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн Б/18 тоот захирамжаар их эмч Л.Амарсанаад буцалтгүй тусламж 1000.0 мянган төгрөг, 2021 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 92 тоот захирамжаар Эрүүл мэндийн салбарын 2020 оны “Оны шилдэг менежер”-ээр шалгарсан тул 1 сарын цалин 934.9 мянган төгрөг нийт 3079.9 мянган төгрөг олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар: Аймгийн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 242319.2 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас 38156.6 мянган төгрөг, сумын ЭМТ-өөс 3517.0 мянган төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтэнүүдийн холбооноос 248.8 мянган төгрөг, авто тээврийн төвөөс 75.0 мянган төгрөг, Сод монгол группээс 7.0 мянган төгрөг, ХААН банкнаас 20.0 мянган төгрөг нийт 284343.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Үүнээс цалингийн зардалд 55805.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 6668.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 2164.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 4356.6 мянган төгрөг, эм боох хэрэгсэлд 116374.9 мянган төгрөг, холбооны зардалд 1238.0 мянган төгрөг, хоол хүнсэнд 9000.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2445.0 мянган төгрөг, багаж, техник, хэрэгсэлд 3294.6 мянган төгрөг, багаж хэрэгсэл 15640.0 мянган төгрөг, дотоод албан томилолтод 500.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 46238.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад 1748.8 мянган төгрөг, нийт 265474.8 мянган төгрөг зарцуулж 18868.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

8.2 Өглөг, авлагын талаар: 2021 онд 353.1 мянган төгрөгийн /эмийн өглөг 353.1/ өглөгтэй, 187351.0 мянган төгрөгийн авлагатай /ажиллагчидтай холбоотой авлага 1686.5 мянган төгрөг, тээвэр шатахууны авлага 1301.0 мянган төгрөг, эмийн авлага 959.8 мянган төгрөг, бусад зардлын тооцооны авлага 183271.1 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 132.5 мянган төгрөг/ тайлан гарсан байна.

8.3.Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2021 оны эхэнд барилга байгууламж 527846.6 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 39485.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 123706.4 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 17729.2 мянган төгрөг, программ хангамж 650.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 14328.0 мянган төгрөг байсанаас төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмжид БСБ электрониксоос зөөврийн

компьютер 1899.9 мянган төгрөг, Хануй булган ХХК-аас хөлдөөгч 780.0 мянган төгрөг, тавилга эд хогшилд Мед буян трейд ХХК-аас билиметр 3200.0 мянган төгрөг, моргын ор 3200.0 мянган төгрөг, Баянхангай агт ХХК-аас ширээ 2000.0 мянган төгрөг, ХААН банкнаас урт сандал 2 ширхэгийн тус бүрийн үнэ 150.0 мянган төгрөг, жижүүрийн ширээ 35.0 мянган төгрөг, Си Ти Эс ХХК-аас прорамын шинэчлэл 1350.0 мянган төгрөг, хандиваар машин тоног төхөөрөмжид аймгийн Эрүүл мэндийн газраас өвчтөний хяналтын монитор 4596.4 мянган төгрөг, хөргөгч 4789.3 мянган төгрөг, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 1317.7 мянган төгрөг, суурин компьютер 1965.5 мянган төгрөгөөр 3 ширхэг, Эрүүл мэндийн яамнаас тарианы автомат шавхуурга 1628.0 мянган төгрөг, сумын Засаг даргын тамгын газраас хүчил төрөгч өтгөрүүлэгч 1820.0 мянган төгрөг, иргэн Б.Бямбажаваас угаалгын машин 360.0 мянган төгрөг, 31 дэх төгсөлтөөс гоожуур 2 ширхэгийг 250.0 мянган төгрөг, иргэн Гал-Эрдэнээс зөөврийн компьютер 1500.0 мянган төгрөг Монгол ардын намаас хүчил төрөгч өтгөрүүлэгч 1000.0 мянган төгрөг нийт 37490.7 мянган төгрөг хөрөнгө орлогодож 594298.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:** 2021 оны эхний үлдэгдэл тусгай зориулалтын материал 13568.4 мянган төгрөг, эм боох материал 9151.9 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1287.6 мянган төгрөг, аж ахуйн материал 10898.1 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1122.0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 155.1 мянган төгрөг, хүнсний материал 3264.5 мянган төгрөг, бусад хангамжийн материал 760.3 мянган төгрөг, мал амьтад 1395.0 мянган төгрөг нийт 41603.1 мянган байсанаас төсвийн хөрөнгөөр 217587.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 259786.5 мянган төгрөг, шилжүүлэн хүнсний материалд 375.0 мянган төгрөг орлогодож 361220.2 мянган төгрөгийн материал зарцуулж 158131.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

#### ЕС. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Жолоочийн тооцоо бодохгүй байгаа нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллаагүй.

2. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан 1 хүнд 100.0 мянган төгрөг олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 1.7-д /Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй/ заасныг зөрчсөн.

3. Хүнсний тайлангаас бусад материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, шаардах хуудасны зөвшөөрсөн баганд дарга бичилт хийдэггүй.

4. Санхүүгийн тайлангийн хүнсний үлдэгдэл 5917875.29 төгрөг, няравын тайлан 6376260 төгрөг, тооллогоор 539128 төгрөгөөр зөрүүтэй.

5. Ковидын оношлуурын тооцоог хийж данс бүртгэлд тусгаагүй.

6. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг программаас гаргаж тооллогын комисс гарын үсэг зурсан, эд хөрөнгийн картыг бүрэн бөглөөгүй нь Төсвийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх, үүрэг, 4-т/ Тооллогын комисс дараахь үүрэгтэй/, 1-д/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах/, 2-т/ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих/, 3-т /агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт,

хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах/, 4-т/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх/, 5-т /эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих/, 5.Тооллогын комисс дараахь эрхтэй, 1-т /тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах/, 2-т/ тооллого явуулахын өмнө эд хариуцагчдын хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох хүмүүст шаардах/ заалтуудыг зөрчсөн.

7. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ цэсэнд 7 сараас хойш байхгүй гэж, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 2021 онд 10, 11, 12 сарын шийдвэр гарсан байхад мөн байхгүй гэж мэдээлсэн. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримтална;/, 6.1.2-т /.....сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу улирлын тайланг дараа сарын 10-ны дотор илгээх байтал 2021 оны 2-р улирлын тайланг 12 дугаар сарын 24-ны өдөр илгээж 5 сар, 4 дүгээр улирлын мэдээлэл илгээгүй, 2022 оны 1,2 дугаар улирлын тайланг илгээгүй зөрчлүүд илэрлээ.

#### АРАВ.АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 төлбөрийн актаар 100.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, албан шаардлага үйлдэж нягтлан бодогч, нярав нарт арга зүйн зөвлөгөө өгөв.

#### АРВАН НЭГ.ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 14.4.2, 14.4.3, 20.1.4, Сангийн сайдын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлтэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна. 353.1 мянган төгрөгийн өр /эм 353.1 мянган төгрөг/, 187350.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.8 /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/ мөрдөж ажлаагүй гэж үзэж байна.

#### АРВАН ХОЁР.ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалын 1 дүгээр хавсралт Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллах.

